

Орон бүхний пролетариат нар нэгдэгтүн! АНХДУГААР ТАВАНЖИЛ

Төв аймгийн Намын Хороо, А.ДХ-ын гүйцэтгэх захиргааны сонин

27 хавь * № 80 (2384) * 1974 оны 10 дугаар сарын 24 * ПҮРЭВ * идээ

СУУРИЙН ХҮМҮҮЖЛИЙН АЖИЛ

Суурийн хүмүүжлийн ажлын үндсэн зорилт нь малчдыг улс төрийн өндөр ухамсартай, нийгмийнхээ өмнө хүлээсэн үүргийг бүрэн ойлгож тавьсан зорилтыг хэрэгжүүлэхийн төлөө идэвх санаачлага гарган ажилладаг болгох явдал юм.

МАХН-ын Төв Хороо «Малчдын дунд зохиож байгаа ухуулга хүмүүжлийн ажлын тухай» тогтоол гаргаж орон нутагт зохиох ухуулга олон түмний ажлын одоогийн шаардлагаас урган гарсан шинэ зорилтыг тодорхойлж түүнийг хэрэгжүүлэх арга замыг зааж өгсөн юм.

Аймгийн Намын хороо өнгөрсөн жил МАХН-ын Төв Хорооны удирдамжийн дагуу сурах бичиг программ заавар боловсруулан гаргаж аймгаас суурийн хүмүүжлийн ажлын зөвлөх багш нарыг томилон ажиллуулж, мал аж ахуйн хэд хэдэн суурь дунд төвлүүлж хийхээр зохион байгуулж ажиллав.

Жаргалант, Борнуур, Өндөрширээт, Эрдэнэсант, Баян-Өнжүүл зэрэг сумын намын байгууллагууд өнгөрсөн хичээлийн жилд суурийн хүмүүжлийн ажлыг шинэ заавар удирдамжийн дагуу зохион байгуулж чанартай сайн явуулжээ.

Гэвч ихэнх сумд зохион байгуулалтыг муу хийж хичээлийг ор нэр болгох, суурийн хүмүүжлийн ажлыг шалган дүгнэж туршлагыг судлан дэлгэрүүлэх, суурийн ахлагч, сум бригадын хариуцагчид мэдээлэл өгөх, хичээлийн сэхээтнийг жигд оролцуулахгүй, суурийг сурах бичгээр бүрэн хангаж өгөхгүй, зарим суурьт хичээл огт заагдахгүй өнгөрөх, багшлах ажлыг суурийн ахлагч, хэсгийн ухуулагчдад хариуцуулан орхидог дутагдал байсаар байна. Суурийн хүмүүжлийн ажлыг ХАА-н үйлдвэрлэлийн одоогийн зохион байгуулалттай нягт холбож бүх бололцоог ашиглан аль болох эмх цэгцтэй, мал аж ахуйн хэсгүүдэд төвлөрүүлж замаар зохион байгуулах хэрэгтэй.

Нам, улсын хариуцагчид, мэргэжлийн сэхээтнүүдийг оролцуулан судлах зүйл тус бүрийг зохих мэргэжлийн бэлтгэлтэй хүнээр заалгах нь хичээлийн нарыг дээшлүүлэх гол нөхцөл юм.

Мөн заах багш нарыг зориуд бэлтгэж цаг үеийн чухал асуудлаар тогтмол семинарлаж байвал зохино.

Суурийн хүмүүжлийн ажлын явц, чанар, ирцийн байдал тусгайлан дүгнэлт хийж, илэрсэн дутагдлыг арилгаж, зөвлөлтөө өгч байх нь багш болон сурагчид хариуцлага идэвх чармайлтыг дээшлүүлэхэд ач холбогдлыг өгнө.

Сурах бичиг, программыг суурь бүрт хүргэж, хичээлийг түүний дагуу амьдралтай сайн холбож чанартай заах нь чухал.

Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн ажлын ололт нь малчин бүрийн ухамсартай үйл ажиллагаа мэдлэгийн хэмжээнээс ихээхэн шалтгаалах учраас мэдлэг боловсрол ялангуяа ХАА-н үйлдвэрлэлийн эдийн засаг технологийн мэдлэгийг дээшлүүлэх шаардлага улам өсөж байна.

Намын байгууллага уг ажлын явцыг байнга анхаарч туршлагыг судлан дэлгэрүүлж, дутагдлыг цаг тухай бүр илрүүлэн засч улс төр хүмүүжлийн ажилд өс төдий хандаж ор нэр болгох, хэлбэрлэх явдлыг гаргахгүй байхад ихээхэн анхаарвал зохино.

Малчдын дунд зохиох хүмүүжлийн ажлын үндсэн хэлбэр-суурийн хүмүүжлийн ажлыг чанартай сайн зохиох явдал орон нутгийн нам, улсын болон ХЗЭ, эмэгтэйчүүд, аж ахуйн байгууллагын улс төрийн үйл ажиллагааны нэг гол зорилт мөн.

„Бат найрамдал” сэдэвт өдөрлөг

Саяхан «Анхдугаар таван жил» сонин СХ-ийн хэвлэх үйлдвэр ээлжит өдөрлөгөө «Бат найрамдал» сэдвээр явуулав.

Өдөрлөгөөр олон мандатын төлөө уралдаанд түрүүлж ЗХУ-д үйлдвэрийн зардлаар жуулчдад ирсэн үсэг өргөч, МХЗЭ-

ийн гишүүн Д.Лхагваатай уулзалт хийсний дээр 3 дугаар улирлын уралдаанаа дүгнэхэд төлөвлөгөөгөө 119,8 хувиар биелүүлсэн Алтангэрэл ахлагчтай хөвлөх тасаг, төлөвлөгөөгөө 103,4—137,2 хувиар биелүүлсэн хэвлэгч Л.Сий-

лэгмаа, А.Намсрай, дэвтэрлэгч Г.Зэсэм нар эхний байрт шалгарав.

Хэвлэгч Л.Сийлэгмаа ЗХУКН-ын Төв Хорооны ерөнхий нарийн бичгийн дарга Л.И.Брежнев манай оронд зочлон ирэх гэж байгаад баярлаж байгаа

Эрхэм дээд зочиндоо барих бэлэг

МАХН-ын Төв Хороо, БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчид, Засгийн газрын урилгаар ЗХУКН-ын Төв Хорооны ерөнхий нарийн бичгийн дарга Л.И.Брежнев тэргүүтэй ЗХУ-ын нам, засгийн төлөөлөгчид манай оронд айлчлан ирэх гэж байгаад ажилчин бид нэн их баяртай байна. Миний бие энэ оны эхний 9 сарын төлөвлөгөөг 115,5 хувиар биелүүлсэн амжилтаа бататгаж, эрхэм дээд зочноо угтаж жилийн төлөвлөгөөгөө хугацаанаас нь 15 хоногийн өмнө 120 хувиар биелүүлэх зорилттай ажиллаж байна. Энэ бол эрхэм дээд зочиндоо ажилчин миний барих хөдөлмөрийн бэлэг болно.

Аймгийн хэлэлтийн үйлдвэрийн 3 улаагийн аварга хэвлэгч, МАХН-ын гишүүн Ч.АЛТАНГЭРЭЛ

КУРГАНЫ ЗОЧИД МАНАЙ АЙМАГТ

Курган мужийн Намын хорооны ахлах лектор, философийн ухааны дэд эрдэмтэн В.А.Сорокин, зохиолч-сэтгүүлч В.Ф.Потанин нар манай аймагт зочлох хугацаандаа улахгүй хагас зуун жилийнхээ ойг тэмдэглэх гэж байгаа Улаанбаатар хотын хөгжилт цэцэглэлтэй танилцах үеэр Курганы эрхэм зочдыг МАХН-ын Төв Хорооны үзэл суртлын хэлтэст зохих мэргэжлийн хүмүүс хүлээн авч тус тусын шугамаар уулзан үзэл суртлын асуудлыг товч ярилцаж туршлага солилцов.

Уулзалт элсгээр догтно байдалд болдоо.

Зочид дараа нь Улсын төв болон хувьсгалын музей үзэж, хотын хөгжилтэй танилцав. Орой

нь манай ууган зохиолч Д.Нацагдоржийн зохиол «Учиртай гурван толгой» гэдэг алдарт дуурийг үзлээ. Зочдыг Улаанбаатар хотын хөгжилтэй танилцахад аймгийн Намын хорооны нарийн бичгийн дарга, МЗНН-ийн аймгийн зөвлөлийн дарга Х.Билгээ, аймгийн А.ДХ-ын гүйцэтгэх захиргааны хариуцагчтай нарийн бичгийн дарга, МЗНН-ийн аймгийн зөвлөлийн орлогч дарга Г.Шарав, «Анхдугаар таван жил» сонин хариуцагчтай эрхлэгч, МЗНН-ийн аймгийн зөвлөлийн тэргүүлэгч гишүүн Д.Товуу нар болон бусад албаны хүмүүс Буянт ухаагийн нисэх онгоцны буудлаас үдэж мордуулав.

Дараа нь аймгийн Намын хорооны нэгдүгээр

нарийн бичгийн дарга Ц.Адъяа зочдыг хүндэтгэж үдэлтийн хоол өгөв.

Зочид 10 дугаар сарын 21-ндэх орондоо буцлаа. Зочдыг аймгийн Намын хорооны нарийн бичгийн дарга, МЗНН-ийн аймгийн зөвлөлийн дарга Х.Билгээ, аймгийн А.ДХ-ын гүйцэтгэх захиргааны хариуцагчтай нарийн бичгийн дарга, МЗНН-ийн аймгийн зөвлөлийн орлогч дарга Г.Шарав, «Анхдугаар таван жил» сонин хариуцагчтай эрхлэгч, МЗНН-ийн аймгийн зөвлөлийн тэргүүлэгч гишүүн Д.Товуу нар болон бусад албаны хүмүүс Буянт ухаагийн нисэх онгоцны буудлаас үдэж мордуулав.

МАНАЙ СУРВАЛЖЛАГЧ

гаруй хүний илтгэл сонсголыг хэлэлцэв.

Хэлэлцсэн асуудалтай холбогдуулан Дорноговь, Сэлэнгэ аймгийн эмийн сангийн удирдах конторын дарга Чулуунбат, Наранцогт, Эм хангамжийн үйлдвэрлэлийн газрын мэргэжилтэн Чунаг, Төв аймгийн Жаргалантын сум дундын болон эмийн сангийн эрхлэгч Намсрайжав, Дорнод аймгийн Цагаан-овоо сумын эмийн сангийн эрхлэгч Зундуй нарын 20-иод хүн уг хэлэв.

Тус зөвлөлтөөнөөс МАХН-ын III их хурал хуралдсаны болон БНМАУ-ыг тунхагласны 50 жилийн ойг угтаж нийгэмийн сангуудыг удирдах конторуудын хамт олныг социалист уралдаанд уриалсан уриалга гаргав.

Мөн зөвлөлтөөнд БНМАУ-ын Эрүүлийг Хамгаалах Яамны нэгдүгээр орлогч сайд Жав, эмийн сангийн байгууллагуудын ажлын одоогийн байдал, цаашдын ажлын талаар зөвлөлтөө өглөө.

Зөвлөлтөөний үеэр манай улсад шинээр гарч байгаа эмүүдээр үзэсгэлэн гаргасны гадна бүсийн зөвлөлтөөнд оролцож байгаа аймгуудын эмийн сангийн удирдах конторууд ажлынхаа арга туршлагыг сурталчлах самбар үзүүлэн нээж ажиллуулав. Дараа нь ажил төрлийн семинар болдоо.

Л.БАДАМЦЭРЭН

Н.НАНЖИД

МАХН-ЫН III ИХ ХУРАЛ ХУРАЛДСАНЫ БОЛОН
БНМАУ-ЫГ ТУНХАГЛАСНЫ 50 ЖИЛИЙН ОЙД

БНМАУ-д ЗХУ-ын үзүүлсэн тусламж, түүний үр дагавар

МАХН, улс орныхоо хөгжилд нөлөөлөх тухайн түүхт нөхцөл байдлыг зөв шинжлэн судлаж, ардын хувьсгалын ололтыг хамгаалан бэхжүүлэхийн төлөө явуулж байсан Монголын ард түмний тэмцлийг Зөвлөлт Орос улсын ажилчин ангийн тэмцэл, олон улсын пролетарийн хөдөлгөөнтэй нягт холбосон, нөгөө талаас Зөвлөлт-Орос улсын ялж дийлсэн пролетари нар түүний коммунист нам, Зөвлөлт төрийн зүгээс Монголын ард түмэнд эдийн засаг, улс төр, цэргийн болоод соёлын талаар ах дүүгийн тусламж үзүүлсэн явдал нь Монгол орон капиталист биш замаар хөгжих эх сурвалж болсон билээ. ЗХУ-ын тусламжтайгаар 1921 онд эл хэрэглэгчдийн харилцаа туслахаа хоршоо байгуулж худалдааны харилцаа тогтоон, Монгол-Зөвлөлтийн хувь нийлүүлсэн худалдаа, аж үйлдвэрийн банк байгуулан 1925 онд мөнгөний реформ хийж үндэсний мөнгөн тэмдэгтийг гаргалаа.

Энэ нь тус улсын зах зээлээс гадаадын худалдаа, мөнгө хүүлэх капиталыг шахан зайлуулж, эдийн засгийн биеэ даасан байдлыг тэмцэн олж бэхжүүлэхэд шийдвэрлэгч үүрэг гүйцэтгэжээ.

Хувьсгалын ардчилсан шатанд тус орны эдийн засгийг хөгжүүлэхэд тохиолдож байсан бэрхшээлийг даван туулахад ЗХУ-ын тусламж шийдвэрлэх үүрэг гүйцэтгэв.

Юуны урьд төв цахилгаан комбинат, аж үйлдвэрийн комбинат, Улаанбаатар-Налайхын нарийн төмөр зам, Хатгалын ноос угаах фабрик зэрэг үйлдвэрийн газрыг ашиглалтад оруулсан байна.

ЗХУ 1937 онд машинаар өвс хадах механикжсан 10 станц байгуулан манай улсад үнэ төлбөргүй шилжүүлж өгсөнөөс гадна төмрийн завод, Баянтүмэн Соловьескийн 230 гаруй км төмөр замыг 1939 онд ашиглалтад оруулжээ. БНМАУ, ЗСБНХУ-ын хооронд 1946 оны 2 дугаар сард байгуулсан найрамдал, харилцаа туслах тухай гэрээ, эдийн засаг, соёлын хамтын ажиллагааны тухай хэлэлцээр нь БНМАУ-д социализмын үндэс суурийг тавих, тусгаар тогтнолыг бэхжүүлэхэд их үүрэг гүйцэтгэв.

Анхдугаар таван жилд тус улсын улс ардын аж ахуйд төвлөрөн журмаар оруулсан нийт хөрөнгийн 45,8 хувийг ЗХУ-аас үзүүлсэн санхүүгийн тусламж эзлэж байлаа.

II таван жилд ЗХУ-ын тусламжаар Улаанбаатарын мебелийн фабрик, талхны завод зэргийг өргөтгөсний гадна Налайхын их уурхайн I ээлж, шаазан ваарын артель, сүүний комбинат, чихэр боовны фабрик зэрэг үйлдвэрийн газрыг шинээр байгуулжээ.

Гурван жилийн төлөвлөгөөний жилүүдэд ЗХУ-ын тусламжаар жилд 600 мянган тонн нүүрс гаргах

Налайхын их уурхай, илчит цахилгаан станц, гурлын комбинат зэргийг барьж байгуулав.

Энэ хугацаанд ЗХУ-ын техник эдийн засгийн тусламжтайгаар 260 мянган га атар газар эзэмшсний дунд улсын тариалангийн нийт талбай 3,2 дахин нэмэгдэж, нэг хүнд ноогдох үр тариаг 268 кг-д хүргэв.

Ийнхүү манай улсад газар тариалангийн ажил улсардын аж ахуйн биеэ даасан салбар болов.

III таван жилд ЗХУ-ын эдийн засгийн тусламжтайгаар Дарханд 50 мянган квт-ийн хүчтэй илчит цахилгаан станц, жилд 1 сая гаруй тонн нүүрс гаргах хүчин чадалтай Шарын голын нүүрсний ил уурхай, өндөр хүчдэлийн шугам, уурхайчдын тосгоны I ээлж зэрэг томоохон барилга байгууламжийг ашиглалтад оруулсан юм.

БНМАУ, ЗСБНХУ-ын хооронд найрамдал хамтын ажиллагааны болон харилцаа туслах тухай шинэ гэрээг 1966 оны нэгдүгээр сарын 15-нд байгуулсан нь манай хоёр орны тал бүрийн нягт хамтын ажиллагааг бэхжүүлэн хөгжүүлэх батүндэс болсон юм.

IV таван жилд ЗХУ иж бүрэн механикжсан өвс хадгалгын 16 бригад, тэжээл тээврийн авто баазыг байгуулж олон мянган худаг гаргаж, үлэмж хэмжээний бэлчээрийг усжуулав.

Мөн үйлдвэрлэлийн бо-
(Төгсгөл нь IV нүүрт)

Аймгийн ХАА-н нэгдлийн
бригадуудыг 1974 оны 3 дугаар
улирын ажлаар социалист
уралдаанд цуваагаар байр
эзлүүлсэн дүн

№	Сумын нэр	Бригадын нэр	Эзлэх байр
1.	Мөнгөнморьт	Үржиг ферм	1
2.	Заамар	Ухаа	2
3.	Өндөрширээт	Баясах	3
3.	Мөнгөнморьт	Байдлаг	4
5.	Өндөрширээт	Баянтуул	5
6.	Эрдэнэ	Эрдэнэ-уул	6
7.	Мөнгөнморьт	Бүрх	7
8.	Сэргэлэн	Хөшиг	8
9.	Заамар	Ундарган	9
10.	Бүрэн	Булангаа	10
11.	Алтанбулаг	Алтанбулаг	11
12.	Баянзүрх	Туул	12
13.	Баян-өнжүүл	Цээл	13
14.	Лүн	Цагаан-уул	14
15.	Бүрэн	Хайрхан	15
16.	Баянзүрх	Тэрлэж	16
17.	Алтанбулаг	Ферм (мал)	17
18.	Баяндэлгэр	Байдлаг	18
19.	Дэлгэрхаан	Давст	19
20.	Баяндэлгэр	Төвийн	20
21.	Өндөрширээт	Уянга	21
22.	Баянзүрх	Баянбүрд	22
23.	Өндөрширээт	Н. р. нбилэг	23
24.	Баянжаргалан	Жаргалант	24
25.	Заамар	Тосон	25
26.	Баянжаргалан	Баян-Эрхтий	26
27.	Эрдэнэ	Нарстай	27
28.	Дэлгэрхаан	Тарган	28
29.	Эрдэнэсант	Баян-уул	29
30.	Эрдэнэ	Хушинга	30
31.	Сэргэлэн	Авдар	31
32.	Лүн	Өгөөмөр	32
33.	Эрдэнэсант	Сайхан	33
34.	Эрдэнэсант	Алтан-уул	34
35.	Мөнгөнморьт	Хэрлэн	35
36.	Лүн	Энх	36
37.	Баян	Цавчир	37
38.	Эрдэнэсант	Угалзат	38
39.	Алтанбулаг	Алтан-овоо	39
40.	Баян-өнжүүл	Бараат	40
41.	Алтанбулаг	Жаргалант	41
42.	Баян	Баян	42
43.	Баян-өнжүүл	Бүрд	43
44.	Баян	Цант	44
45.	Баяндэлгэр	Гунталуут	45
46.	Бүрэн	Баянцогт	46

Баянцагаан сумын «Өрнөх-амьдра» нэгдэл бригадуудынхаа ажлын дүнг ирүүлээгүй учир уралдаанд байр эзлүүлээгүй болно.

Аймгийн ХАА-н нэгдлийн зөвлөл

МОНГОЛЫН ЭНХ ТАЙВНЫ ХӨДӨЛГӨӨНИЙ 25 ЖИЛИЙН ОЙД

БНМАУ-ЫН ЭНХ ТАЙВАНЧ ГАДААД БОДЛОГО

БНМАУ тусгаар тогтнолоо олсон анхны өдрөөс эхлэн энх тайвныч гадаад бодлогыг тууштай явуулж дэлхий нийтийн энх тайвны үйлст зохих хувь нэмрээ оруулсаар ирлээ.

Нийтийн дайсан гитлерийн-фашистуудын өдөөн дэгдээсэн дэлхийн II дайны хүнд хүчир жилүүдэд Зөвлөлтийн баатарлаг ард түмэн, түүний улаан армийн ялалтыг түргэтгэхийн тулд Монголын ард түмэн санаа сэтгэл, эд материалын тусламж үзүүлж байлаа. 1939 онд манай халдашгүй дархан хил хязгаарт Японы милитаристууд халдан довтлож ирэхэд БНМАУ-ын Засгийн Газрын хүсэлт, 1936 оны харилцаа туслах протокол ёсоор ЗХУ цэрэг зэвсгийн тусламж үзүүлсэн бөгөөд Монгол-Зөвлөлтийн дайчид Халхын голын районд Японы самуурай нарт үхлийн

цохилт өгсөн явдал алс дорнодод улс түмний энх амгаланг хамгаалах үйлст оруулсан том хувь нэмэр болов.

1945 онд манай ардын арми, Зөвлөлтийн улаан армитай мөр зэрэгцэн явж японы милитаристуудыг бүрмөсөн бут цохилдод бичлэн оролцсон юм.

Манай ард түмэн энхрийн хайрт МАХН-ынхаа зөв мэргэн удирдлагын дор 50 гаруй жилийн түүхэн замыг туулахдаа өөрийн орны, социалист бүтээн байгуулалтанд асар их амжилтыг олж, харийн түрэмгийлэгчдийн эсрэг, империализмын эсрэг, улс түмний найрамдал нөхөрлөл, хамтын ажиллагааны төлөө тэмцэж ирсэн тэр ариун шударга тэмцэл бол бүхэлдээ энх тайвны төлөө тэмцэл билээ. «Энх тайвныг хамгаалах явдал бол дэлхийн бүх ард түмний үйл хэргэг» гэсэн уриан доор

1949 оны 4 дүгээр сарын 20—25-нд Прага, Парис хотноо болсон дэлхий дахины энх тайвны талынхны анхдугаар их хуралд Монголын ард түмнийг төлөөлж нөхөр Ю. Цэдэнбал тэргүүтэй манай төлөөлөгчид оролцсоор Монголын ард түмний энх тайвны төлөө тэмцэл дэлхийн улс түмний энх тайвны төлөө тэмцэл хөдөлгөөний салшгүй бүрэлдэхүүн хэсэг болсон юм.

1949 оны 10 дугаар сарын 21—22-ны өдрүүдэд Улаанбаатар хотноо Монголын найрамдлын талынхны анхдугаар бага хурал хуралдаж нөхөр Ю. Цэдэнбал «Шинэ дайныг өдөөгчдийг эсэргүүцэн, улс түмний өнө урт бат найрамдлын төлөө» гэсэн илтгэл тавьсан ба Монголын энх тайвны үндэсний анхны байгууллага болох найрамдлын талынхны байнгын товчоог бий болгосон нь цаашид

өргөжин энх тайвныг хамгаалах Монголын хороо байгуулагджээ.

Өнгөрсөн 25 жилийн дотор Монголын ард түмэн дэлхийн энх тайвны байгууллагын баримталж байгаа чиг шугам үйл ажиллагааг бүрэн дэмжиж түүнийг ажил хэрэгт идэвхтэй оролцон, гаргасан шийдвэр, уриа тунхагийг нь амжилттай хэрэгжүүлж ирлээ.

1950 оны Стокгольмын уриалганд манай 700 мянган шахам хүн гарын үсэг зурсан хийгээд 1951 онд БНМАУ-ын Бага Хурлын Тэргүүлэгчид «Энх тайвны хуулийг» тунхагласан нь Монголын ард түмэн, түүний засгийн газрын энх тайвныг чин эрмэлзлэлийн бас нэг тод илрэл болсон билээ.

1950 оны эхээр БНАСАУ-ын эсрэг Өмнөт Солонгосын хөлсний этгээдүүд болон Америкийн империалистуудын дэгдээсэн түрэмгий дайн, 1956 онд Бүгд Найрамдах Египет улсын эсрэг Англи, Франц, Израилийн түрэмгийлэгч-

дийн үйлдсэн халдлага, 1962 оны Карибын тэнгисийн хямрал, 1967 оны 6 дугаар сард Арабын орнуудыг эсрэг Израилийн түрэмгийлэгчдийн дахин хийсэн түрэмгийллийн үед Монголын ард түмэн тэдгээр империалист халдлагын эсрэг туйлбартай тэмцэж, түрэмгийлэлд өртсөн улс түмэнд зохих дэмжлэг тусламж үзүүлэн тэдний талд гуйваат гүй зогсож байлаа.

БНМАУ, Ази тивд оршдог социалист орны хувьд дэлхийн бөмбөрцгийн энэ хэсэгт энх амгалан байдлыг бэхжүүлэхийн төлөө тууштай тэмцэж ирлээ.


Энэтхэг—Хятадын орнуудын ард түмэн, түүний дотор ах дүү Вьетнамын ард түмэн Америкийн империалист түрэмгийллийн эсрэг гартаа зэвсэг барин тэмцсэн өдрөөс эхлэн Монголын ард түмэн БНАВУ болон Өмнөт Вьетнамын баатарлаг эх орончлод санаа сэтгэл, эд материалын тусламж тасралтгүй үзүүлж ирсэн юм.

Курган мужийг сурталчлах 7 хоног



Аймгийн Намын хорооны нэгдүгээр нарийн бичгийн дарга Ц. Адъяа, Курган мужийн Намын хорооны ахлах лектор, эрдэмтэн В. А. Сорокин, ЗХУ-ын зохиолчдын холбооны гишүүн, зохиолч-сэтгүүлч В. Ф. Потанин нарыг хүлээн авч уулзав.

Зураг дээр:
Нөхөр Ц. Адъяа, зочидтой ярилцаж байна.



Эрдэмтэн В.А. Сорокин Зуунмод хотод болсон хөдөлмөрчдийн цуглаан дээр үг хэлж байгаа нь.



Манай зочид аймагт айлчлахдаа тэргүүний олон сайчуудтай уулзсан юм.

Гэрэл зургийн хальсанд

ЗСБНХОУ-ын Курган муж, тус аймаг хоёрын хамтран ажиллах 1974 оны төлөвлөгөө ёсоор Курган мужийн төлөөлөгчид энэ оны 10 дугаар сарын 14—21-ийг хүртэл тус аймагт зочилж Курган мужийг сурталчлах долоо хоногийн ажилд оролцов.

Энэ үеэр Курганы зочдын оролцсон зарим онцлог үйл явдлуудыг манай гэрэл зургийн эвлүүлгээс үзэж болно.



1. Манай зочин эрдэмтэн В.А.Сорокин, зохиолч-сэтгүүлч В. Ф. Потанин нар Батсүбэрийн САА-н 8 жилийн дунд сургуулийн хүндэт пионер болсон юм.

Зураг дээр: (Баруун тараас)

В. А. Сорокин, В.Ф.Потанин нар.

2. Зохиолч Виктор Потанин Борнуурын САА-н хоньчин С. Хүрлээтэй уулзаж ярилцав.

С. ДОЛ-ын авсан гэрэл зураг

Вьетнамд дайн зогсож энх тайван байдал сэргэн тогтсон нь олон улсын түгшүүрийн аюулт голомтын нэгийг устгах сайхан эхлэл болсон билээ.

Гэвч Вьетнамын талаархи Парисын хэлэлцээрийн заалтуудыг Сайгоны дэглэм зөрчсөөр байна.

Парисын хэлэлцээрийг нарийн чанд дагаж мөрдөн, түүний бүх заалтыг хэлбэрэлтгүй биелүүлэхийн төлөө БНӨВУ-ын хувьсгалт түр засгийн газрын тууштай байр суурь, идэвхтэй чармайлтыг монголын олон нийт шийдвэртэй дэмжиж байна. БНМАУ цөмийн зэвсгийг гурван орчинд туршихыг цаазлан хориглох тухай Москвагийн гэрээ, цөмийн зэвсгийг үл дэлгэрүүлэх тухай олон улсын гэрээнд нэн түрүүнд нэгдэн нийлсэн нь манай улсын энх тайванд гадаад бодлогын бас нэг илрэл билээ.

ЗХУКН-ын XXIV их хурлаар баталсан энх тайвны программ амьдралд амжилттай хэрэг-

жиж түгшүүртэй байдлыг намжаах үйл явцад гарч байгаа бодит алхам, зөөлөн уур амьсгал өнөөгийн олон улсын байдлын гол шинж чанар болж байна.

Энх тайвны төлөө тэмцэгчдийн эгнээнд шинэ шинэ хүчнүүд нэгдэн нийлж, түүний үйл ажиллагааны хүрээ, далайц улам өргөжин тэлсээр байгаагаар барахгүй орчин үеийн хамгийн өргөн олныг хамарсан хүчирхэг хөдөлгөөн болон хувирлаа. Монголын ард түмэн ЗХУ, социалист хамтын нөхөрлөлийн орнуудын ард түмэнтэй ах дүүгийн барилдлагаа найрамдал хамтын ажиллагаагаа улам бэхжүүлэн зузаатгахын зэрэгцээгээр дэлхийн дөвшилт хүчин, шударга түмэнтэй харилцаа холбоогоо өргөтгөн дайн дэлхийн үйл түмний энх тайвны үйлст зохих хувь нэмэр оруулсаар байна.

Монголын ард түмний энх тайвны төлөө тэмцлийн үйл ажиллагааг дэлхийн энх тайвны зөвлөлдэлхийн улс түмэн өнд-

рөөр үнэлж байна.

1966 онд манай нам, төрийн ахмад зүтгэлтэн агсан Ж. Самбууг «улс түмний хооронд энх тайвныг бэхжүүлэхийн төлөө олон улсын Лениний шагналаар, өнгөрсөн онд МАХН-ын Төв Хорооны нэгдүгээр нарийн бичгийн дарга, БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн дарга нөхөр Ю.Цэдэнбалыг Фредрик Жолио-Кюригийн нэрэмжит энх тайвны алтан медалиар шагнасан явдал болон, Энх тайвныг Хамгаалах Монголын Хороо, Монголын олон нийтийн зүтгэлтэн хэд хэдэн хүн ДЭТЗ-ийн дээд шагнал хүртсэн явдал үүнийг нотлон харуулж байна.

Энэ өндөр үнэлэлт бол улс түмний аюулгүй байдал, энх тайван социализмын үйлст хэлбэрэлтгүй үнэнч манай ард түмний асар их хүчин зүтгэл гайхамшигт хөдөлмөрийн бахдам сайхан үр дүн мөн.

Д. ДЭМБЭРЭЛДАШ
Б. ЦЭРЭНДАШ

ЛЕНИНИЙ ОДОТ КУРГАН МУЖ

—Зөвлөлт Курган муж 71,7 мянган хавтгай дөрвөлжин км нутаг, 1 сая 68 мянган хүн амтай.

Тус мужид аж үйлдвэрийн 250 гаруй газар ажилладаг ба дэлхийн 50 гаруй оронд бүтээгдэхүүнээ гаргадаг. Мужийн хэмжээгээр хоёр сая гаруй мал, 700 мянган гахай, төрөл бүрийн 2850 мянган шувуу үржүүлдэг.

Мужид 232 хамтрал, 135 САА, 5 дээд, 21 тусгай мэргэжлийн дунд сургууль ажилладаг.

—1973 оны байдлаар мужийн хүн амын хэрэгцээнд 48 мянган зурагт радио, 64 мянган радио хүлээн авагч, 70 гаруй мянган радио зангилаа үйлчилж байв.

Мөн 60 мянган хувь хэвлэгддэг «Советское зауралье», «Молодой Ленин» сонинноос гадна район бүр өөрийн сонинтой ба тэдгээрт 300 гаруй сэтгүүлд ажилладаг байна.

Хувьсгалын өмнө Кур-

ганы 50 мянган хүнд 1 их эмч ноогдож байсан бол одоо 10 мянган хүнд 18 их эмч үйлчлэх болсны дээр 40 орчим их эмч ЗСБНХОУ-ын гавьяат их эмч цол хүртжээ.

IX таван жилд Курган хотынхон 862 мянган квадратметр талбай бүхий орон сууц хүлээн авна. Тус мужийн хөдөлмөрчдийн материаллаж байдал жилээс жилд үлэмж дэгжин дээшилж байна. 1973 оныг 1967 онтой харьцуулахад хүн амын мөнгөн орлого 40 хувиар өсчээ. Мөн олон тооны клуб, соёлын орд, номын сан, кино театр, биеийн тамир спортын зэрэг урлаг, соёлын газрууд хөдөлмөрчдөд үйлчилж байна. Курганчууд одоо «Дөрвөн өдөрт таван өдрийн ажил» хийх хөдөлгөөн өрнүүлэн IX таван жилийн төлөвлөгөөг биелүүлэх ажилдаа улам шинэ амжилт олж байна.


Б. ЦЭРЭНДАШ

Курган мужийг сурталчлах 7 хоног



Аймгийн Намын хорооны нэгдүгээр нарийн бичгийн дарга Ц. Адъяа, Курган мужийн Намын хорооны ахлах лектор, эрдэмтэн В. А. Сорокин, ЗХУ-ын зохиолчдын холбооны гишүүн, зохиолч-сэтгүүлч В. Ф. Потанин нарыг хүлээн авч уулзав.

Зураг дээр:
Нөхөр Ц. Адъяа, зочидтой ярилцаж байна.



Эрдэмтэн В.А. Сорокин Зуунмод хотод болсон хөдөлмөрчдийн цуглаан дээр үг хэлж байгаа нь.



Манай зочид аймагт айлчлахдаа тэргүүний олон сайчуудтай уулзсан юм.

Гэрэл зургийн хальсанд

ЗСБНХОУ-ын Курган муж, тус аймаг хоёрын хамтран ажиллах 1974 оны төлөвлөгөө ёсоор Курган мужийн төлөөлөгчид энэ оны 10 дугаар сарын 14—21-ийг хүртэл тус аймагт зочилж Курган мужийг сурталчлах долоо хоногийн ажилд оролцов.

Энэ үеэр Курганы зочдын оролцсон зарим онцлог үйл явдлуудыг манай гэрэл зургийн эвлүүлгээс үзэж болно.



1. Манай зочин эрдэмтэн В.А.Сорокин, зохиолч-сэтгүүлч В. Ф. Потанин нар Батсүбэрийн САА-н 8 жилийн дунд сургуулийн хүндэт пионер болсон юм.

Зураг дээр: (Баруун тараас)

В. А. Сорокин, В.Ф.Потанин нар.

2. Зохиолч Виктор Потанин Борнуурын САА-н хоньчин С. Хүрлээтэй уулзаж ярилцав.

С. ДОЛ-ын авсан гэрэл зураг

Вьетнамд дайн зогсож энх тайван байдал сэргэн тогтсон нь олон улсын түгшүүрийн аюулт голомтын нэгийг устгах сайхан эхлэл болсон билээ.

Гэвч Вьетнамын талаархи Парисын хэлэлцээрийн заалтуудыг Сайгоны дэглэм зөрчсөөр байна.

Парисын хэлэлцээрийг нарийн чанд дагаж мөрдөн, түүний бүх заалтыг хэлбэрэлтгүй биелүүлэхийн төлөө БНӨВУ-ын хувьсгалт түр засгийн газрын тууштай байр суурь, идэвхтэй чармайлтыг монголын олон нийт шийдвэртэй дэмжиж байна. БНМАУ цөмийн зэвсгийг гурван орчинд туршигч цаазлан хориглох тухай Москвагийн гэрээ, цөмийн зэвсгийг үл дэлгэрүүлэх тухай олон улсын гэрээнд нэн түрүүнд нэгдэн нийлсэн нь манай улсын энх тайванд гадаад бодлогын бас нэг илрэл билээ.

ЗХУКН-ын XXIV их хурлаар баталсан энх тайвны программ амьдралд амжилттай хэрэг-

жиж түгшүүртэй байдлыг намжаах үйл явцад гарч байгаа бодит алхам, зөөлөн уур амьсгал өнөөгийн олон улсын байдлын гол шинж чанар болж байна.

Энх тайвны төлөө тэмцэгчдийн эгнээнд шинэ шинэ хүчнүүд нэгдэн нийлж, түүний үйл ажиллагааны хүрээ, далайц улам өргөжин тэлсээр байгаагаар барахгүй орчин үеийн хамгийн өргөн олныг хамарсан хүчирхэг хөдөлгөөн болон хувирлаа. Монголын ард түмэн ЗХУ, социалист хамтын нөхөрлөлийн орнуудын ард түмэнтэй ах дүүгийн барилдлагаа найрамдал хамтын ажиллагаагаа улам бэхжүүлэн зузаатгахын зэрэгцээгээр дэлхийн дэвшилт хүчин, шударга түмэнтэй харилцаа холбоогоо өргөтгөн дайн дэлхийн үйл түмний энх тайвны үйлст зохих хувь нэмэр оруулсаар байна.

Монголын ард түмний энх тайвны төлөө тэмцлийн үйл ажиллагааг дэлхийн энх тайвны зөвлөлдэлхийн улс түмэн өнд-

рөөр үнэлж байна.

1966 онд манай нам, төрийн ахмад зүтгэлтэн агсан Ж. Самбууг «улс түмний хооронд энх тайвныг бэхжүүлэхийн төлөө олон улсын Лениний шагналаар, өнгөрсөн онд МАХН-ын Төв Хорооны нэгдүгээр нарийн бичгийн дарга, БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн дарга нөхөр Ю.Цэдэнбал-дыг Фредрик Жолио-Кюри-ийн нэрэмжит энх тайвны алтан медалиар шагнасан явдал болон, Энх тайвныг Хамгаалах Монголын Хороо, Монголын олон нийтийн зүтгэлтэн хэд хэдэн хүн ДЭТЗ-ийн дээд шагнал хүртсэн явдал үүнийг нотлон харуулж байна.

Энэ өндөр үнэлэлт бол улс түмний аюулгүй байдал, энх тайван социализмын үйлст хэлбэрэлтгүй үнэнч манай ард түмний асар их хүчин зүтгэл гай-хамшигт хөдөлмөрийн бахдам сайхан үр дүн мөн.

Д. ДЭМБЭРЭЛДАШ
Б. ЦЭРЭНДАШ

ЛЕНИНИЙ ОДОНТ КУРГАН МУЖ

—Зөвлөлт Курган муж 71,7 мянган хавтгай дөрвөлжин км нутаг, 1 сая 68 мянган хүн амтай.

Тус мужид аж үйлдвэрийн 250 гаруй газар ажилладаг ба дэлхийн 50 гаруй оронд бүтээгдэхүүнээ гаргадаг. Мужийн хэмжээгээр хоёр сая гаруй мал, 700 мянган гахай, төрөл бүрийн 2850 мянган шувуу үржүүлдэг.

Мужид 232 хамтрал, 135 САА, 5 дээд, 21 тусгай мэргэжлийн дунд сургууль ажилладаг.

—1973 оны байдлаар мужийн хүн амын хэрэгцээнд 48 мянган зурагт радио, 64 мянган радио хүлээн авагч, 70 гаруй мянган радио зангилаа үйлчилж байв.

Мөн 60 мянган хувь хэвлэгддэг «Советское зауралье», «Молодой Ленин» сонинноос гадна район бүр өөрийн сонинтой ба тэдгээрт 300 гаруй сэтгүүлд ажилладаг байна.

Хувьсгалын өмнө Кур-

ганы 50 мянган хүнд 1 их эмч ноогдож байсан бол одоо 10 мянган хүнд 18 их эмч үйлчлэх болсны дээр 40 орчим их эмч ЗСБНХОУ-ын гавьяат их эмч цол хүртжээ.

IX таван жилд Курган хотынхон 862 мянган квадратметр талбай бүхий орон сууц хүлээн авна. Тус мужийн хөдөлмөрчдийн материаллааж байдал жилээс жилд үлэмж дэгжин дээшилж байна. 1973 оныг 1967 онтой харьцуулахад хүн амын мөнгөн орлого 40 хувиар өсчээ. Мөн олон тооны клуб, соёлын орд, номын сан, кино театр, биеийн тамир спортын зэрэг урлаг, соёлын газрууд хөдөлмөрчдөд үйлчилж байна. Курганчууд одоо «Дөрвөн өдөрт таван өдрийн ажил» хийх хөдөлгөөн өрнүүлэн IX таван жилийн төлөвлөгөөг биелүүлэх ажилдаа улам шинэ амжилт олж байна.

Б. ЦЭРЭНДАШ

ЗАРЛАЛ

Бэрэдэн сумын харьяат Лувсан Овогтой Жан-
ваа иргэдийн 330263 нэмэрт үнэмлэхээ үргэлжлүүл-
гч туга хүчинтгийг тооцлов.